

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 7 ХОНОГИЙН ТАЙЛАН
/2022.09.12- 2022.09.16/

2022.09.16

Дархан-Уул аймаг

№	Ажлын чиглэл	Үйл ажиллагааны гүйцэтгэл
Барилга хот байгуулалтын хэлтэс		
1	Барилга угсралтын чиглэлээр	<ul style="list-style-type: none"> ✓ Засгийн газрын 212-р тогтоолын дагуу 2 нийтийн орон сууцны барилга байгууламжид ашиглалтад оруулах комиссыг зохион байгуулж ажилласан. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Эм жи эл туннель системс ХХК-ний 45 айлын орон сууц - Баян бридж ХХК-ний 108 айлын нийтийн орон сууцны барилга ✓ Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.31, 2.77, 5.1.12 дахь зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хүрээнд хийгдсэн 2021-2023 ондуудад ашиглалтад орсон болон орох нийтийн орон сууцны судалгааг ирүүлсэн маягтын дагуу Барилгын хөгжлийн төвд хүргүүлсэн. ✓ Дархан-Уул аймгийн Засаг даргын 2022 оны 01-04/07 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд намрын ургац хураалтад манай байгууллагаас оролцох албан хаагчдыг нэрсийг ирүүлсэн маягтын дагуу хүнс, хөдөө, аж ахуйн газарт хүргүүлсэн.
Газрын удирдлагын хэлтэс		
1	Геодези, зураг зүйн чиглэлээр	<ul style="list-style-type: none"> ✓ Хаягийн зургийн дагуу 15 иргэн, 8 аж ахуйн нэгжийн эзэмшлийн газар, үл хөдлөх эд хөрөнгөд хаяг дугаар олгосон. ✓ Шинээр үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ авахаар /хувийн сууц , гараж, барилга байгууламж, хуваалт / хэмжилт хийлгэсэн 12 иргэн, 3 аж ахуйн нэгжийн материалыг хүлээн авч мэдээлийн санд оруулж кадастрын зураг гаргасан. ✓ Геодези, зураг зүй, кадастрын зураглалын ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй “Гео од”, “Ёлт сүрвэй” ХХК-ний хийж гүйцэтгэсэн барилга байгууламж, зам, талбай, инженерийн шугам сүлжээний 8 улаан шугам, 2 гүйцэтгэлийн зургийг хэлээж авсан. ✓ Цагдаагийн газрын мөрдөн байцаах тасагт шалгагдаж байгаа гэмт хэргийн бүртгэлийн 913 дугаартай гомдол мэдээлэлд өгөгдсөн цэгийн байршлыг харуулсан зургийг гаргаж албан бичгээр хүргүүлсэн. ✓ Иргэн Ө.Бадамын 2022 оны 06 сарын 13 нд Дархан-Уул аймгийн ГХБХБГ-т гаргасан өргөдөл гомдолыг хянаж үзээд эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй дур мэдэн хашаа, байшин барьсан цахилгааны шугам татсан буруутай үйл ажиллагаа байх тул газрын гэрчилгээ олгуулах, өмч хөрөнгийг хохиролгүй болгуулах асуудлыг манай байгууллага шийдвэрлэх боломжгүй болохыг мэдэгдэж хариуг хүргүүлэв. ✓ Мэргэжлийн хяналтын газраас “Очир-Ундраа” ХХК-ний гаргасан зөрчилд шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж байгаа газарт авагдсан солбицолыг кадастрын мэдээллийн санд оруулж шалгалган тухайн солбицол нь Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутаг дэвсгэр Бууртын орчим Зоолуур харын хөндийд байрлах тус компианы ашигт малтмалын эзэмшлийн талбайд байрлаж байгааг тодотгон хариуг хүргүүлсэн. ✓ Дархан хотын гэр хороололын бүсээс мал туслах аж ахуйг гаргах, хотын ногоон байгууламжид мал оруулахгүй байх ажлыг эрчимжүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу малтай иргэдэд олгосон газарт очиж төлөвлөлтийн дагуу буусан эсэхэд шалгалт хийлээ. Нийт 12 айл төлөвлөлтөөр олгосон байршилд буусан байна.

	Газрын кадастрын чиглэлээр	<ul style="list-style-type: none"> ✓ Шинээр үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ авахаар /хувийн сууц , гараж, барилга байгууламж, хуваалт / тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагуудаар хэмжилт хийлгэсэн 5 иргэний материалыг хүлээн авч мэдээлийн санд оруулж кадастрын зураг гаргасан. ✓ Өмчлөлийн газраа худалдах, өвлүүлэх, бэлэглэх гэрээгээр шилжүүлж байгаа нийт 13 иргэний цахим хүсэлтийг мэдээллийн санд өөрчлөлт хийж, кадастрын зургийг гаргаж өгсөн. ✓ Дархан сумын Засаг даргын орлогч П.Ихбаяраар ахлуулсан ажлын хэсэгт орж Гэр хорооллын бүсээс мал, туслах аж ахуйг гаргах, зөвшөөрөлгүй буусан, газар чөлөөлөх шаардах хуудас хүргүүлсэн айлууддаа хяналт тавьж нүүгээгүй 2 айлыг албадан нүүлгэж ажилласан. ✓ Шинэчилсэн бүртгэлд орох шаардлагатай 96 нэгж талбарын нөхөн бүрдүүлэлтийг хийсэн. ✓ Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дэргэдэх Газрын эрх зүйн харилцааг хянан шийдвэрлэх хуралд : Хамтран өмчлөгч хасуулах 4 иргэн, өмчилсөн газрын талбай хэмжээ өөрчлөх 13, Эзэмшил газрын талбай хэмжээ өөрчлөх 1, Шинээр өмчлөх хүсэлт өгсөн 13 иргэний материалыг бэлтгэж хуралд оруулсан.
	Газар зохион байгуулалтын чиглэлээр	<ul style="list-style-type: none"> ✓ Аймгийн Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон Прокурорын газарт шалгагдаж байгаа иргэн, ААНБ -ын нийт 10 албан бичгийн лавлагааг газрын кадастрын системээс аймгийн хэмжээнд шүүж хариуг хүргүүлсэн. ✓ Дархан-Уул аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх хуралд оролцсон. /Батбармат ХХК ✓ Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дэргэдэх газрын эрх зүйн харилцааг хянан шийдвэрлэх хурлаар нийт 39 иргэн, хуулийн этгээдийн ирсэн хүсэлтийг хэлэлцүүлэн, хариуг албан тоотоор хүргүүлсэн. ✓ 2023 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ байршил, зориулалтыг Дархан сумын иргэдийн төлөөлөгчдийн зөвлөлийн хурлаар эхний байдлаар хэлэлцүүлсэн.
Захиргаа аж ахуйн чиглэл		
1	Захиргаа, хүний нөөц, хууль эрх зүй	<p>Шүүх:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Батбармат ХХК-ний нэхэмжлэлтэй аймгийн Засаг даргад холбогдох захиргааны хэргийн урьдчилсан хэлэлцүүлгээр 2022/09/16-ны хуралдсан боловч нэхэмжлэгч талын итгэмжлэгдсэн төлөөлөгч шүүх хурлыг хойшлуулах хүсэлт гаргасан, нэхэмжлэгчийн өмгөөлөгчөөс нэхэмжлэгчээс нэмж нотлох баримт гаргуулхаар тул мөн хойшлуулах хүсэлт ирүүлсэн. Шүүх хуралдааны 2022/09/29-ны өдрийн 08:30 тов зарласан. ✓ Жоконди ХХК, Айтүүлс ХК, Батбармат ХХК, Отгон, Эрхэмсэг оршихуй БСБ-нэхэмжлэлтэй захиргааны хэрэгт шүүхээс дээрх маргаан бүхий газарт үзлэгээр хамт газрын дарга Д.Батчулуун, Б.Баярмаа, Б.Золбаясах нар байлцсан <p>Хүний нөөц:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Дархан сумын газрын даамал Ө.Мягмарсүрэнгийн аав хагалгаанд орсон, түүнийг асрах хүсэлт ирүүлсний дагуу газрын даргын тушаалаар чөлөөг олгосон. <p>Газрын хурал:</p> <ul style="list-style-type: none"> ✓ 2022/09/16-ны өдөр Газрын эрх зүйн хуралдаанд 8 мэргэжилтэн хуралдаанд оролцож, Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил, үүссэн тухай мэдэгдэлээ бөглөсөн. https://meduuleg.iaac.mn/AOS/ мэдүүлгийг сайтад бөглөсөн.

2	Мэдээллийн технологи, нярав	<p>Мэдээлэл: 70376471 нээлттэй утсаар 0 иргэн /Нүүж өөр өрөөнд орсон тул утасны үзүүр орж ирээгүй тул/, байгууллагын Facebook хуудсанд ирсэн 6 иргэн, ААНБ-ын асуултанд хариулт өгөв.</p> <p>Мэдээллийн технологи: Мэргэжилтнүүдийн хаягийг хэвлэж наав. Мэргэжилтнүүдийн QR кодыг хэлтэс тус бүрээр нь байрлуулан постерын эх бэлтгэн хэвлэж, байгууллагын үүдэнд байрлуулав. Тайланг АЗДТГ руу илгээв. 2 компьютер форматлаж, хэрэглээний програмуудыг суулган, тохиргоог хийж, хэвлэгч, сканерыг таниулав. Smart city төсөлд зориулсан цахим шилжилтийн танилцуулгыг бэлтгэж, АЗДТГ-т очин танилцуулав. Илтгэлийн файл, шаардлагатай төхөөрөмжийн судалгааг АЗДТГ-ын мэргэжилтэн рүү илгээв.</p> <p>Нярав: 10 ширхэг Нэгж талбарын хувийн хэрэг нугалж мэргэжилтнүүдэд олгоход бэлтгэв. Газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтнүүдэд 17 ширхэг нэгж талбарын хувийн хэргийн хавтас олгож, кадастрын мэдээллийн санд өөрчлөлт оруулсны төлбөрийн баримт 35 ширхэгийг хүлээж авч бүртгэв. Шаардах хуудсаар 4 төрлийн 11 ширхэг бараа материал олгов.</p>
---	--------------------------------	--

Тайлан боловсруулсан:
Захиргаа, хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Хянасан:
Газрын удирдлагын хэлтсийн дарга

Б.Золбаясах
Г.Нямдорж